

## **ТЕХНИК ИМПОРТ ХК**

### **2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Компанийн нэр: Техник импорт ХК

Компанийн хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125

Регистрийн дугаар: 2057239

Компанийн утас: 70001830

Цахим шуудан: info@technikimport.mn

### **ТАНИЛЦУУЛГА**

Техник импорт ХК нь анх 1958 онд “Техник Импорт Хангамжийн Нэгдэл” нэртэйгээр үүсгэн байгуулагдсан Монгол Улсын гадаад худалдааны ууган компаниудын нэг бөгөөд аж үйлдвэр, барилга, эрчим хүч, уул уурхай, харилцаа холбоо зэрэг салбаруудыг хөгжүүлэхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, сэлбэг материалыг холбогдох газруудын захиалгаар импортлон нийлүүлэх үйл ажиллагааг явуулж ирсэн.

1990 онд төрийн өмчит нээлттэй хувьцаат компани болон өөрчлөгдөж 1998 онд нээлттэй дуудлага худалдаагаар хувьцаа нь арилжаалагдаж, 100 хувь хувийн өмчит “Техник импорт” ХК болж өөрчлөгдөн гадаад худалдаа, барилгын материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Компани нь гадаад худалдаа, бизнесийг өргөжүүлэх талаар холбогдох судалгааны ажлуудыг хийж төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд жилээс жилд үйл ажиллагааны хүрээ өргөжин тэлж бараа бүтээгдэхүүний төрөл, тоо нэмэгдэж зарим бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтээр монгол улсын зах зээлд тэргүүлэх байр суурийг эзэлж байна.

Техник импорт ХК нь үйлчлүүлэгч, хэрэглэгч, харилцагч байгууллагуудаа эрхэмлэн дээдэлж, олон улсын чанар, стандартад нийцсэн бараа бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах, бизнесийн таатай орчин бүрдүүлэхийг эрмэлзэхээс гадна компанийн засаглалыг хөгжүүлж ил тод байдлыг баримтлан ажиллах, нийгмийн хариуцлагыг идэвхтэй хэрэгжүүлэх, үндэсний шилдэг бүтээн байгуулагч компани болох зорилт тавин ажиллаж байна.

### **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Техник импорт ХК нь 2021 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд компанийн 2021 оны бизнесийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулж ажиллалаа. Үүнд:

1. Хөтөл Цемент Шохой ХК, Мак Цемент ХХК-ийн цементийг гэрээний дагуу худалдан борлуулах,

2. ОХУ-ын бараа бүтээгдэхүүн /хөргөгч, угаалгын, машин, гэр ахуйн сав, суулга, замын битум/ худалдан борлуулах
3. БНХАУ-ын мотоциклийн үйлдвэрээс мотоцикл, мотоциклийн сэлбэг хэрэгслийг импортлон аймаг, хот, хөдөө орон нутагт болон өөрийн компанийн нэрийн барааны дэлгүүрээр худалдан борлуулах
4. Дархан хотын “Төмөрлөгийн үйлдвэр”-ээс арматурыг зохих хэмжээгээр харилцагч аж ахуйн нэгж, байгууллагад гэрээний үндсэн дээр нийлүүлж худалдан борлуулах
5. Өөрийн эзэмшлийн байрыг ажлын байрны зориулалтаар аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүст түрээслүүлэх

## **1. Компанийн удирдлага, зохион байгуулалтын талаар**

Компани нь 2021 оны хагас жилд 60 гаруй ажилтантай, дараахь бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа зохион байгуулж ажиллалаа.

1. Гүйцэтгэх захирал
2. Дотоод аудитын алба
3. Захиргаа
4. Санхүү бизнес хариуцсан алба
5. Санхүү, бизнес хөгжлийн алба
6. Үйл ажиллагаа хариуцсан алба
7. Харуул, аж ахуйн үйлчилгээний алба

## **2. 2021 оны хагас жилийн үйл ажиллагааны талаар**

2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас батлагдсан 2021 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөний дагуу компанийн удирдлагаас цемент, мотоцикл, битум, арматур, ОХУ-ын гэр ахуйн цахилгаан бараа худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажилласнаас гадна байгууллагын дотоод үйл ажиллагааны хүрээнд компанийн байранд ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулдаг Түрээслэгч нарт болон компанийн удирдлагаас ажилчдын нийгмийн асуудал түүнтэй холбоотой бусад асуудлуудыг шийдвэрлэх талаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

- Сар шинийн баярт зориулан нийт ажилчдад япон цагаан будаа, гурил өгсөн.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр нийт ажилчдын хүүхдэд бэлэг өгсөн.
- Компанийн удирдлагаас ажилчдын өргөдөл, хүсэлтэд үндэслэн ажилтнуудад буцалтгүй тусламж үзүүлсэн.
- Цар тахлын улмаас халдвар авсан компанийн ажилтнуудад дархлаа дэмжих, вирусыг устгах, халуун бууруулах шаардлагатай витамин, эмнүүд болон мөнгөн тусламжийг үзүүлсэн.
- Төрийн одон медалиар шагнагдсан компанийн 4 ажилтанд хүндэтгэл үзүүлж дурсгалын зүйлс, мөнгөн шагналыг компанийн холбогдох дүрэм, журмын дагуу олгосон.
- Түрээслэгч нарт 3 удаа түрээсийн төлбөрөөс 50%-ийн хөнгөлөлт үзүүлсэн.
- Компанийн ажилчдыг болон Түрээслэгч нарыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллыг хангуулах зорилгоор компанийн үүдний хаалганд халуун хэмжигч,



барилгын давхрын шат бүрт савтай ариутгачийг тус тус байрлуулж, компани дотор болон шатан дээр зай барьж явах, зайнаас харьцаж байхаар холбогдох тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан.

- Компанийн ажилчдын дархлааг дэмжих зорилгоор ажилчдад өдөр бүр витамин С, Д, 2 ээлжийн маск өгч ажилласан.
- Компанийн нийт ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах гэрээг байгуулж гэрээний үндсэн дээр компанийн нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан.

### **Аж ахуйн чиглэлээр**

- Компанийн гаднах талбайг тохижуулах ажлын хүрээнд компанийн гадна талын ногоон байгууламжинд 7 ширхэг сөөг мод суулгаж зүлгэжүүлсэн.
- Компанийн харуул болон ажилчдын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор харуулын 2,3-р постын байрыг болон ажилчдын хувцас солих өрөөг засварлаж тохижуулсан.
- Компанийн ажилчдын ажлын дүрэмт хувцсыг шинээр захиалан ажилчдад олгосон.

### **Санхүүгийн чиглэлээр**

- 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд гаргаж, Баян ташаагийн эх аудитын компаниар аудитын дүгнэлт хийлгэж Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж тайлагнасан.

Техник импорт ХК болон компанийн харьяа охин компаниуд 2018 оноос эхлэн тухайн оны үйл ажиллагааны тайланг дараа оны 01 дүгээр сард багтааж бусад компанийн удирдлагууд, зохих ажилтнуудад тогтмол тайлагнадаг болсонтой холбогдуулан Техник импорт ХК-ийн гүйцэтгэх удирдлагаас өөрийн харьяа охин компаниудын удирдлагуудад 2020 оны үйл ажиллагааны тайлан бэлтгэж тайлагнахтай холбоотой бэлтгэл ажлыг хангахад анхаарч ажиллах талаар үүрэг, даалгавар өгч биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан.

## **3. Компанийн засаглалыг хэрэгжүүлж байгаа талаар**

### **Хувьцаа эзэмшигчдийн хурал**

Компанийн Дүрмээр “Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна” гэж заасан.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн тухай хуульд заасны дагуу жил бүр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулдаг.

2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2021 оны 04-р сарын 13-ны өдрийн 15 цагт компанийн “Хурлын танхим”-д цахим хэлбэрээр хуралдуулж дараах асуудлуудыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж хэлэлцүүлсэн. Үүнд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-аас өгсөн дүгнэлт
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон ногдол ашгийн тайлан
3. Компанийн 2021 оны бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөө
4. ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8 % нь оролцсон ба хурлаар хэлэлцэх асуудлуудын талаар хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахад хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид дэмжиж 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

“Компанийн тухай хууль”-д заасны дагуу 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн “Нэр дэвшүүлэх хороо”-ноос ирүүлсэн шаардлагыг хангасан 3 хүнийг 2021 оны ТУЗ-ын хараат бус гишүүнээр, 6 хүнийг ердийн гишүүнээр тус тус сонгож баталсан. ТУЗ-ын гишүүнээр сонгогдсон ердийн болон хараат бус нийт 9 гишүүн, ТУЗ-ын нарийн бичгийн дарга компанийн засаглалын сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан.

2021 оны ТУЗ-ын гишүүдийн бүрэлдэхүүн:

Хараат бус гишүүн: 1. Ж.Баярсайхан  
2. Б.Батсайхан  
3. Б.Нарантуяа

Ердийн гишүүн: 1. Д.Баяраа  
2. Т.Тунгалаг  
3. Г.Уран-Өлзий  
4. С.Бүжинлхам  
5. Э.Батболд  
6. Ж.Уртнасан

Техник импорт ХК нь жил бүр Хувьцаа эзэмшигчдийн хуралд өмнөх оны ногдол ашиг олгосон эсэх талаарх тайлан, ТУЗ-аас гаргасан ногдол ашгийн талаарх тогтоол, шийдвэрийг танилцуулж тайлагнадаг.

Ногдол ашгийн талаар:

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 2019 оны ногдол ашгийн талаарх тайланг тавьсан. Мөн 2020 онд ногдол ашиг олгох эсэх талаар ТУЗ-аас гаргасан шийдвэр, тогтоолыг танилцуулсан.

#### **Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл**

Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн удирдлагыг хэрэгжүүлдэг бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж,



тэднийг төлөөлж компанийн “Дүрэм” болон “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-аар олгосон эрх, үүргийн хүрээнд компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан шийдвэр, тогтоолыг хэрэгжүүлэх, компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, компанийн гүйцэтгэх удирдлагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

### **ТУЗ-ын Аудитын хороо**

ТУЗ-ын Аудитын хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Компанийн тухай хууль болон компанийн ТУЗ-ын үйл ажиллагааны журамд заасан эрх, үүргийн хэмжээнд компанийн нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн санхүүгийн дотоод хяналт нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль дүрэмд нийцсэн байдал, эрсдлийн удирдлагын бодлого стратегийг тодорхойлох, эрсдлийн удирдлагын болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, хараат бус аудитын байгууллагыг сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн Удирдах Зөвлөлд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог бүрдүүлэхэд оршдог.

Компанийн дотоод аудитын алба нь ТУЗ-ын дэргэдэх аудитын хорооны удирдлаганд харьяалагдаж ажилладаг ба компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж сар, улирал, жилээр ажлаа тайлагнаж ажилладаг.

### **Нэр дэвшүүлэх хороо**

Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТУЗ-ын гишүүд, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, сонгон шалгаруулах, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх, ТУЗ-ын гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх чиглэлээр ТУЗ-аас чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслахад оршино.

### **Цалин урамшууллын хороо**

Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь компанийн ТУЗ-аас ТУЗ-ын гишүүд, гүйцэтгэх удирдлага, бусад эрх албан тушаалтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих, цалин урамшуулал олгох санал боловсруулах, компанид мөрдөгдөж байгаа ажлын үр дүн дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж үр дүнг үнэлэх чиглэлээр ТУЗ-аас чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршдог.

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор компанийн үйл ажиллагаатай уялдуулан тодорхой чиглэлээр гаргаж буй хороодын дүгнэлттэй танилцах, хороодын дүгнэлтийг ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргах, шаардлагатай тохиолдолд хороодоос шийдвэр гаргуулах эрхтэйгээр ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүд хамрах асуудал, чиг үүргийн хүрээний дагуу ТУЗ-аас зөвлөмж, үүрэг, даалгаврыг компанийн удирдлагад өгч хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилладаг.

Төлөөлөн Удирдах зөвлөл, түүний хороод нь өөрсдийн эрхлэх чиг үүрэгтэй холбогдуулан компанийн бизнес үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн үйл ажиллагааны явц, байдлын талаар компанийн Гүйцэтгэх удирдлагаас сар тутам ажлын тайлан, мэдээлэл авч хянан холбогдох үүрэг, чиглэлийг өгч ажилладаг.

2021 оны компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар ТУЗ-ын ердийн гишүүнээр Т.Тунгалаг, Д.Баяраа, Э.Батболд, С.Бүжинлхам, Г.Уран-Өлзий, Л.Уртнасан, хараат бус гишүүнээр Ж.Баярсайхан, Б.Нарантуяа, Б.Батсайхан, ТУЗ-ын даргаар Т.Тунгалаг нар тус тус сонгогдож компанийн Гүйцэтгэх захиралаар Д.Ганцэцэг ажиллаж байна.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2021 оны эхний хагас жилд Компанийн тухай хууль, компанийн “Дүрэм”, “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д заасны дагуу

1. 2020 оны ногдол ашиг хуваарилж олгох эсэх тухай
2. 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай
3. Банктай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

асуудлаар тус тус 3 удаа хуралдаж ТУЗ-ын гишүүдийн дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэж тогтоол гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

### **Гүйцэтгэх удирдлага**

Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн Газар Ковид-19 цар тахлын улмаас улсын хэмжээнд 3 удаа хөл хорио тогтоосон нь компаниас үндсэн чиглэлийнхээ дагуу үйл ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээлийг учруулсан ч Улсын Онцгой Комиссоос гаргасан шийдвэрийн хүрээнд компаниас үйл ажиллагаа явуулах хугацаандаа Гүйцэтгэх удирдлагаас компанийн хэмжээнд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж компанийн бизнесийн болон төлөвлөгөөт зорилтуудыг биелүүлэхийн төлөө хичээж ажиллалаа.

Өнгөрсөн хагас жилийн хугацаанд манай компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос ирүүлсэн “Даалгавар өгөх тухай” албан бичиг болон Монголын Хөрөнгийн Биржээс баталж ирүүлсэн тогтмол мэдээлэл хүргүүлэх тухай хуанлийн дагуу тогтоосон хугацаанд компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2020 оны ногдол ашиг олгох эсэх тухай, 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 сарын 25-ны өдрийн хурлын шийдвэр, тогтоолыг Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд тус тус хүргүүлж ажилласан ба Хороо, Хөрөнгийн биржид хүргүүлсэн тайлан, мэдээллийг холбогдох хуульд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаст байршуулж, олон нийтийг компанийн тухай мэдээллээр хангах үүргээ биелүүлж ажиллалаа.



Техник импорт ХК нь 2021 оны хагас жилийн байдлаар 53,5 тэрбум төгрөгний борлуулалт хийж, улсын төсөвт 7,167,214,17 төгрөгний татвар төлж, 137,3 сая төгрөгийн /татварын дараах ашиг /ашигтай ажиллаж 2021 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан бизнесийн болон ажлын төлөвлөгөөт зорилтуудыг биелүүлэхийн төлөө хичээж ажиллалаа.

Техник импорт ХК-ийн Гүйцэтгэх захирал



Д.Ганцэцэг